

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2023.11.15

Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн ажлыг гэр бүл, олон нийтийн оролцоо дэмжлэгт тулгуурлан зохион байгуулах, хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанар, үр дүнг сайжруулахад орон нутгийн онцлогт тохирсон хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэхэд салбар дундын уялдаа холбоог эрчимжүүлэх хүрээнд тус газар, харьяа соёлын байгууллагууд олон талт үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

Соёлын урлагийн газар:

Хүүхэд хамгааллын чиглэлээр:

1. Тус газар нь “Хүүхэд хамгааллын жил”-ийн хүрээнд хийгдэх ажлын 14 заалт бүхий төлөвлөгөөг 2023 оны эхний улирал буюу /2023.02.27/-ны өдөр газрын даргаар батлуулан одоог хүртэл хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тогтоолийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу аймгийн Соёл, урлагийн газрын даргын 2022.10.06-ны өдрийн А/13 тоот тушаалаар “Эцэг эхийн зөвлөл”-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.

3. Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс аймгийн Соёл, урлагийн “Эцэг эхийн зөвлөл”-өөс газрын пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хандсан нөлөөллийн ажлууд, зөвлөмж бүхий зурагт хуудсыг тогтмол хийж байгаа бөгөөд тайлант хугацаанд шинэ жил, цагаан сар, сурагчдын амралт, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх болон ахуйн ослоос урьдчилан сэргийлэх агуулга бүхий нийт 26 удаагийн зураг хуудасны эх бэлтгэж, иргэдэд олон нийтэд сурталчилсан байна.

4. Байгууллагын албан хаагчдад хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогийг таньж мэдэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг эзэмшүүлэх сургалтыг 2023.05.22-ны өдөр зохион байгуулж, Хүүхдийн номын ордноос зохион байгуулсан Зохиолч, уншигчдын уулзалтад 2023.11.05-ны өдөр албан хаагчдын 3 хүүхдийг хамруулсан.

5. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчдад хүүхдийнх нь мэндэлсэн өдрөөр цалинтай чөлөө олгож, хүүхдэдээ халамж анхаарал тавих боломжийг олгон бага насны хүүхэдтэй эцэг, эхэд хүүхдээ сургууль, цэцэрлэгт хүргэж өгөх авах, эргүүлд гарах, эцэг эхийн хуралд очих, хүүхдийнхээ соёл, хүмүүжлийн өдөрлөгт оролцох зэрэгт цагийн зохицуулалтыг хийж ажиллалаа.

Тайлан, судалгааны чиглэлээр:

1. 2023.03.30-ны өдрийн 167 тоот албан бичгийн дагуу тус газар нь 2023 оны 01 дүгээр улирлын “Хүүхэд хамгааллын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2023.04.10-ны өдөр, 2023.10.10-ны өдрийн 2-10/1231 тоот 2023 оны хүүхэд хамгааллын жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган 2023.11.15-ны өдөр ГБХЗХГ-ын darhan@fcy.gov.mn хаягт тус тус хүргүүлэв.

2. 2023.10.23-ны өдрийн 338 тоотын албан бичгээр ЗГХА СУГ-т Хүүхэд хамгааллын чиглэлээр соёлын салбараас дэвшүүлсэн уриалгын дагуу харьяа соёлын байгууллагуудаас 2023 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэн авч хүргүүлсэн.

3. Тус газрын 7 албан хаагчийн 0-18 хүртэлх насны хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг гаргасан. Үүнээс цэцэрлэгт 2, ЕБС-д 6 хүүхэд суралцаж байна.

Тусламж үйлчилгээний чиглэлээр:

1. Аймгийн Залуучууд театрын дэргэдэх “Шонхоодой” циркийн хүүхдүүдээс ирсэн хүсэлтийг аймгийн Улаан загалмайн хороонд уламжилж хүнсний болон ахуйн хэрэглээний тусламж үзүүлсэн.

2. “Зүрхэнд Гэрэлтэнэ” МУСК-ны 30 ширхэг билетийг Дарханы Аутизмтай хүүхдийн эцэг эхийн холбоонд бэлэглэсэн.

3. Соёл, урлагийн үзвэр үйлчилгээний худалдаалагдсан тасалбарын 1%-ийг хүүхдийн хөгжил, хамгаалалд зарцуулах тухай албан бичгийг соёлын байгууллагуудад хүргүүлсэн.

4. 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Залуучууд театрын шинэ уран бүтээл “Толбот Цагаан” хүүхдийн мюзикл жүжгийг Соёл, урлагийн газрын албан хаагчдын хүүхдүүдэд үзүүлэв.

5. Орхон сумын Соёлын төвөөс “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийг угтан зохион байгуулсан уралдаанд идэвхтэй оролцсон тус сумын 8 дугаар сургуулийн 5 дугаар ангийн 20 хүүхдэд “Зүрхэнд Гэрэлтэнэ” МУСК-ны 20 ширхэг билетийг аймгийн Соёл, урлагийн газраас гардууллаа. Өсвөр насны хүүхдүүдийг хүсэл мөрөөдлийнхөө төлөө зүтгэх, амьдралын зорилготой болгох зам тээврийн осол, гэмтлээс сэргийлэх уриатай энэхүү уран бүтээл 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Залуучууд театрт нээлтээ хийсэн.

6. “Кинонд ээлтэй хот” болох зорилтын хүрээнд Дархан Өргөө кино театр нь 450 хүүхдэд кино үзэх эрх олгов. Тус эрхийн бичгийг аймгийн Засаг даргын Тамгын газарт өгөв.

7. Дархан-Уул аймгийн Засаг даргын нэрэмжит ЕБС, техник мэргэжлийн коллежийн оюутан, сурагчдад эх оронч үзлийг төлөвшүүлэх “БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ” төсөлд аймгийн Соёл, урлагийн газар нь хамтран ажиллав. Төслийн хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдөр “ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ” соёлын өдөрлөгийг Залуучууд театрт зохион байгуулсан. 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр “ДӨЛ” цогцолбор тэмцээний “Тусгай байр”-анд шалгарсан ЕБ-ын 9 дүгээр сургуулийн тасагт баяр хүргэж ном, баярын бэлгийг гардууллаа.

2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Төрийн Ордонд зохион байгуулагдсан “Хүүхдэд ээлтэй Монгол” хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн чуулганаар бүх салбар, яам, агентлаг, нийслэл, орон нутаг, хүүхдийн хөгжил хамгааллын иргэний нийгмийн байгууллагуудаас хүүхдийн өмнө хүлээх үүргээ хариуцлагатайгаар ухамсарлаж ажиллахаа амлан тодорхой уриалгуудыг дэвшүүлсэн.

Тус уриалгын дагуу Дархан-Уул аймгийн Соёлын байгууллагууд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулж, хэвшил болгон ажиллаж байна. Үүнд:

Аймгийн Төв номын сан:

Нэг: Хөшиг нээгдэх бүрд хүргэх үг: “Оюунлаг хүүхдийн төлөө”

Боловсрол олгох чиглэлээр: Хүүхэд хамгаалах жилийн ажлын хүрээнд Төв номын сан нь Сум хөгжүүлэх санд хүүхдийн ном авах 5 сая төгрөгийн төсөл бичиж хэрэгжүүлснээр фондын баяжилтыг орчин үеийн хүүхдийн 274 нэр төрлийн 506 боть номоор бүрдүүлснээр хүүхдийг номтой нөхөрлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд таатай нөхцөлийг бий болгосон.

Бага насны хүүхдэд зориулсан зурагт ном, үлгэрийн комик номноос гадна ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдад зориулан элсэлтийн ерөнхий шалгалтын болон өсвөр насныханд зориулсан уран зохиолын номоор номын фондыг нэмэгдүүллээ. Мөн Англи улсаас “МС Childrens book” төслийн хамт олны хандиваар ирсэн англи хэл дээрх 1000 боть номыг номын сангийн программд бүртгэж үйлчилгээнд оруулсан.

Хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны

хөтөлбөрийн үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёл зан заншил өв уламжлалаа дээдлэх, соёлын үнэт зүйлсийг эзэмших, хамгаалах сэтгэхүйг хөгжүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг олгох, хамтдаа судалж суралцах, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилтын хүрээнд аймгийн Төв номын сангаас номын сангийн боловсролын хөтөлбөрийг эхлүүлээд байна.

Энэ ажлын хүрээнд нийт 5 ангийн 185 сурагч оролцож “Монгол үндэсний хувцсны түүх” сэдвээр лекц хийж, сампин зангидах, н омын хавчуурга хийх зэрэг сургалт явууллаа.

Үүнд:

- 1 дүгээр улирал - "Монгол бахархал"
- 2 дугаар улирал - "Ном бид 2"
- 3 дугаар улирал - "Байгалиа урлая"
- 4 дүгээр улирал - "Би Монгол хүүхэд" г.м.

Тайлангийн хугацаанд “Оюунлаг хүүхдийн төлөө” уриан дор соёлын боловсрол олгох, хамтдаа суралцах, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилтын хүрээнд “Оюунлаг дарханчууд” өдөрлөгийг зохион байгуулав. Өдөрлөгт Шарын гол сумын 2 дугаар сургуулийн 130 сурагч, 6 дугаар сургуулийн 120 сурагч, 14 дүгээр цэцэрлэгийн 70 хүүхэд, 1 дүгээр сургуулийн ахлах ангийн 60 сурагч, Орхон сумын ЕБ-ын сургуулийн 150 сурагч, 9 дүгээр цэцэрлэгийн 60 хүүхэд зэрэг 8 сургууль, цэцэрлэгийн **834** хүүхэд багачууд хамрагдлаа.

Өдөрлөгөөр: ЕБС-ийн сурагчдад:

- Аймгийн ГБХЗХГ-ын хүүхдийн эрхийн улсын байцаагч А.Мягмаржаргал "Эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт лекц
- 15 минутын ном уншлага
- "Болгар дахь Америкын их сургуулийн танилцуулга"
- Номын сангийн электрон каталоги
- "Өөрийгөө хөгжүүлье", "Залуу хүний заавал унших ном" сэдэвчилсэн номын үзэсгэлэн зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

Сургуулийн өмнөх боловсролын хүүхэд багачуудад:

- “Миний анхны англи хэл”,
- "Номын ертөнцөөр аялцгаая" сэдэвчилсэн номын үзэсгэлэнг хүргэж,
- Зурагт уншлага хийж номын тухай ярилцан
- Монгол ардын үлгэрээр чанга уншлага зохион байгууллаа.

Хоёр: Хүүхэд хөгжлийн хувийг бий болгоно

Төв номын сан нь Уншигч хүүхэд багачуудад номоор үйлчлэхээс гадна тэдний сэтгэхүйг хөгжүүлэхэд тус дэм болох зорилгоор шатар, даам тоглох булан байгууллаа.


Мөн уншигч болон ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг урьдчилан сэргийлэхэд зориулсан анхан шатны үзлэгийн аппарат, хэрэгслийг байршуулав.



2023 оны өөрийн орлогын 1 % нь 59410 төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс доорх зардлууд гараад байна.

- ✓ Эрүүл мэндийн анхны тусламжийн хайрцаг төв болон салбар номын сан дээр 540 000 төгрөг
- ✓ Хүүхэдийг эрсдлээс хамгаалах зорилгоор Төв, салбар номын сангийн барилгын гадна болон дотор талыг камержуулахад 1 703 000 төгрөгийг тус тус зарцуулж нийтдээ аюулгүй ажиллагааг хамгаалахад **2 243 000** төгрөгийг зарцуулсан байна.

Мөн "Хүүхэд хамгааллын жил", "Эрсдэлгүй Дархан" аяны хүрээнд Дархан-Уул аймгийн Төв номын сан бүрэн камержлаа. Байгууллагын гадна талбай болон танхимуудад камерыг суурилуулсан бөгөөд номын сангийн орчинд ном дэвтэр, цүнх хувцас зэрэг хаяж гээсэн зүйлээ олж авахаас эхлээд эд хөрөнгийн эвдрэл гэмтэл, уншигчдын дэг журам сайжрахад үр дүнгээ өгч эхлэв.



Хүүхдийн номын ордон:

Нэг: Хөшиг нээгдэх бүрд хүргэх үг: “1-рт хүүхэд – Оюунлаг Дарханчуудыг бүтээнэ. Ирээдүйн уншигчдыг хөтөлнө”

Үйл ажиллагааны эхлэл болон цахим орчинд байнга хэрэглэж, уриалж хэвшсэн.

- ❖ Соёл, олон нийтийн 12 арга хэмжээг зохион байгуулж, үйл ажиллагааны хүрээнд давхардсан тоогоор 28090 тус уриалгыг хүргэсэн.
- ❖ Тус уриалгыг цахим орчинд оны эхний 9 сарын байдлаар 12829 дагагчдад, 321 мэдээллийг давхардсан тоогоор 178,680 хэрэглэгчдэд хүргэж ажилласан.

Хоёр: Хүүхэд хөгжлийн хувийг бий болгоно.

Хүүхдийн соёлын орчныг нэмэгдүүлэх чиглэлээр:

- ✓ 2023 онд өөрийн орлогыг хүүхэд багачуудын сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор цахилгааны эх үүсвэрийг шинэчлэн татах, шинэ танхимын засвар үйлчилгээ хийх, тоног төхөөрөмж техник хэрэгслээр хангах, суудлын тоог нэмэгдүүлэх, үйлчилгээний цагийг уртасгах зэрэг арга хэмжээнд 12 100 000 төгрөг буюу 100% зарцуулсан.
- ✓ 2023 онд өөрийн орлогыг **/2023 оны эхний 10 сарын байдлаар 6 150 500 төгрөг/**
 - Хүүхэд багачуудын сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх;
 - Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор цахилгааны эх үүсвэрийг шинэчлэн татах;
 - Шинэ танхимын засвар үйлчилгээ хийх, тоног төхөөрөмж техник хэрэгслээр хангах, суудлын тоог нэмэгдүүлэх;
 - Үйлчилгээний цагийг уртасгах зэрэг арга хэмжээнд 100% зарцуулсан.

Хүүхэд хамгааллын чиглэлээр халтиргаа гулгаанаас үүдсэн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын үүдэнд 2x2 /4m²/ харьцаатай резинэн шалавч **600.000 /9.7% /** төгрөгөөр худалдан авч байршуулсан.

Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

- ✓ Уншигч хүүхдүүдийн эрэлт хэрэгцээ шаардлагыг үндэслэн шинээр 2 дугаар давхарын уншлага үйлчилгээний танхимыг өргөтгөн засч тохижуулан суудлыг тоог 30-аар нэмэгдүүлэн анги нийтээрээ болон хэсэг бүлэг, найз нөхөд, баг хамт олноороо номын сангийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэн ажилласнаар уншигчдын тоо 10%-иар өссөн.
- ✓ Оны эхний 9 сарын байдлаар уншигчдын эрэлт хэрэгцээ, судалгааг үндэслэн 8,758,672 төгрөгийн 192 нэрийн 429 боть номоор сан хөмрөгөө баяжуулсан.

“Тэгш оролцоотой хүүхэд хөгждөг, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг” зарчмын хүрээнд:

- ✓ Номын сангийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд 4490 уншигч шинээр бүртгэгдэж, 38082 ирэгсдэд, 49293 ном, хэвлэлээр үйлчилсэн. Тус Хүүхдийн номын ордонд Дархан-Уул аймгийн Дархан суманд сурч байгаа ЕБС-ийн нийт /25614/ суралцагчдын 16,9 % нь буюу 4343 хүүхэд, СӨББ-ийн /8037/ суралцагчдын 1.05% нь буюу 85 хүүхэд номын сангийн уншигч болж, уншлага үйлчилгээнд хамрагдсан үзүүлэлттэй байгаа юм.
- ✓ Гэрээр 325 уншигчид 1439 боть ном, зөврөөр 1320 боть ном нүүдлийн номын сангийн үйлчилгээгээр нийт 9 удаа 3176 уншигчид, 5935 боть номоор үйлчилсэн.
- ✓ Ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах, ном унших арга барилд төлөвшүүлэх, мэдлэг, авьяас чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Соёл Олон Нийтийн ажлыг уламжлалт хэлбэр болон цахим хэлбэрээр 5 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 28090 гаруй уншигч, хэрэглэгчдийг хамарсан.
- ✓ Мөн ЕБС-ийн сурагчдын хичээлээс гадуурх чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх, танилцуулах, бие даан сурч боловсроход нь дэмжин туслах, мэдээ мэдээллээр хангах, зөвлөн туслах, хоцрогдол арилгах, ЭЕШ болон бусад уралдаан тэмцээнд оролцоход бэлтгэх зорилгоор Англи хэл, Байгалийн ухаан, Монгол хэл-бичиг, Team Room, Чөлөөт уншлага үйлчилгээний “BOOK & COFFEE танхимууд ажиллаж байна. 2023 оны эхний 10 сард төрөлжсөн танхимуудад нийт 1553 уншигч бүртгэгдэж, 9836 ирэгсдэд 10468 лавлагаа мэдээлэл өгч, ном хэвлэлээр үйлчилсэн байна.

Үндэсний өв соёл шингэсэн цахим контентуудыг бүтээхэд бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд:

Монгол улсын засгийн газраас баталсан соёл урлагийн үйл ажиллагаатай холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийг Хүүхдийн номын ордны хэмжээнд хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд:

1. Хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан “Соёлын боловсрол олгох” хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталгаажуулж, мөрдөж ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд:
 - ❖ “Угийн бичиг хөтлөх” арга зүйд сургах сургалт зохион байгуулах;
 - ❖ “Даам тоглож сурцгаая” аян өрнүүлэх;
 - ❖ “Кино ээлтэй Дархан” арга хэмжээний хүрээнд кино урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох орчин бүрдүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулж нийт **22** удаагийн үйл ажиллагаанд **2199** хүүхдийг хамруулаад байна.
2. Хүүхдийн зусланд нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэх үйл ажиллагааны хүрээнд ардын уламжлалт /шагайн/ тоглоом наадгайг зусланд амрагч **220** гаруй хүүхдүүдэд уралдаан тэмцээн явуулж сургах хэлбэрээр сурталчлан таниулах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

Залуучууд театр:

Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр соёлын салбарын авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Дархан-Уул аймгийн Залуучууд театр нь дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулж, хэвшил болгон ажиллаж байна. Үүнд:

Нэг: Хөшиг нээгдэх бүрд хүргэх үг: “Бид соёлыг түгээж ирээдүйн соёлтой үзэгчийг бэлтгэнэ.

Хоёр. Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, олон нийттэй харилцах ажлыг нэмэгдүүлэх чиглэлээр

Залуучууд театрын шинэ уран бүтээл зохиолч Д.Бибиш, найруулагч Г.Саранчимэгийн “Толбот цагаан” хүүхдийн мюзикл жүжиг нь нийт 26 удаа тоглогдож 8952 хүүхдэд хүрч үйлчилсэн байна.

Гурав. “Тэгш оролцоотой хүүхэд хөгждөг, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг” зарчмын хүрээнд:

3 дугаар улирлын байдлаар Соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 11 дугуйлантай хамтран ажиллах гэрээ хийн ажиллаж байна. Үүнд:

- Дууны дугуйлан -1
- Драмын дугуйлан -2
- Хөгжмийн дугуйлан -4
- Бүжгийн дугуйлан -3
- Шонхоодой цирк – 1

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл”-ийг баталсан 03 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд албан байгууллага бүр хүүхдийн язгуур эрхийг нэн тэргүүнд тавьж ажилтан албан хаагчдаа гэр бүл, үр хүүхэддээ цаг гаргахад нь дэмжлэг үзүүлж, хүүхдэд ээлтэй шийдвэр гаргахыг Аймгийн Засаг дарга, аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн гаргасан 0-18 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд хүүхдийн “Мэндэлсэн өдөр”-өөр тухайн өдрийн цалинтай чөлөө олгох асуудалд хяналт тавьж ажиллаж байна.

Дөрөв. Хүүхдийн соёлын орчны таатай орчин, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр:

- ✓ Хүүхэд багачуудын үзвэрийн таатай орчин бүрдүүлэх зорилгоор их танхимын дулааны шугам хоолойн засвар шинэчлэлтийн ажлыг хийлээ.
- ✓ Хүүхэд багачуудын аюулгүй байдлыг хангах зорилгоор 1 давхрын фоеи болон үзвэрийн их танхим, дугуй танхимд гэрэлтүүлгийг нэмэгдүүлж хамгаалалтын хаалтыг хийлээ.
- ✓ Үйлчилгээний ажилтан н.Отгонжаргалаас ирсэн өргөдлийн дагуу Залуучууд театрын захиргаа, эцэг эхийн зөвлөл хамтран газар дээр нь ажиллаж үйлчилгээний ажилтан Б.Отгонжагалын хүүхдийг тусгай сургалттай 12 дугаар сургуулиас шилжүүлэн сурах нөхцөл бололцоог хангах үүднээс ДУА –ийн ЕБС-ын 15 дугаар сургууль шилжүүлэн ажиллалаа.

Тав. Үндэсний өв соёл шингэсэн цахим контентуудыг бүтээхэд бодлогоор дэмжих арга хэмжээний хүрээнд:

“Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”-ийг байгууллагын нийт ажилтан албан хаагчид болон бусад хүмүүст харагдахуйц газарт байрлуулсан сурталчлан ажиллаж байна. Хүүхдийн аюулгүй байдлын талаарх хүүхдийн эрхийг хамгаалах мэдээллийн самбарыг байршууллаа.

“Нэгдүгээрт хүүхэд” уриан дор Залуучууд театрын сошиал хуудас, Дархан хотын зарын группүүдэд замын хөдөлгөөний дүрмийн талаар фостер бэлтгэн мэдээлэл түгээж ажиллаж байна.

“Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”-ийг байгууллагын нийт ажилтан албан хаагчид болон бусад хүмүүст харагдахуйц газар байрлуулан сурталчлан ажиллаж байна. Хүүхдийн аюулгүй байдлын талаархи хүүхдийн эрхийг хамгаалах мэдээллийн самбарыг байршууллаа.

Хоёр: Хүүхэд хөгжлийн хувийг бий болгоно

Залуучууд театр нь 2023 онд төлөвлөгөөт ажлын хүрээнд хүүхэд уруу чиглэглэсэн 3 ажил зохион байгуулан ажилласан. Үүнд:

- 3 сард “Хорвоод ганцхан ээждээ” мартын 8 өдрөөр тоглож 1 980 000 төгрөг,
- 4-5 саруудад Сэлэнгэ аймаг болон 5 суманд шидэт модны үр хүүхдийн жүжгээр аялан тоглолт хийж 7880 000 төгрөг,
- 6 сард төлөвлөгөөт уран бүтээл “Толбот цагаан” хүүхдийн жүжгээр 49 430 000 төгрөг нийт 59290 000 төгрөгийн орлого олсон байна.

2023 онд нийт **664 700** төгрөгөөр эх үрсийн баяраар байгууллагын ажилчдын бага, дунд насны хүүхдүүдийн дунд зургийн уралдаан зохион байгуулж түүнээс 6 хүүхэд, орон нутгийн олимпиад болон тэмцээн уралдаанд бусдыгаа манлайлан медаль авсан 11 сурагчдад тус тус гарын бэлэг гардуулсан.

Аймгийн Музей:

Нэг: Хөшиг нээгдэх бүрд хүргэх үг. “Хүүхдэд Ээлтэй Монгол”


1. “Хүүхдэд ээлтэй Монгол” хүүхдийн өмнө хүлээх хариуцлагын хүрээнд Аймгийн Музейн албан хаагчид өдөр бүр үйлчлүүлж буй үзэгч болон хүүхдүүдэд Музей үзэх соёл, хүүхдийн эрхийн тухай, хүүхдийн аюулгүй байдал, хүүхэд хүмүүжлийн тухай тараах материал, боловсролын хөтөлбөрийн ажлын хуудасны ард хэвлэн хүүхдүүдэд хүргэв.

2023 оны 11 дүгээр сарын байдлаар нийт **10871** үзэгчдэд мэдээлэл түгээсэн байна.



2. Боловсролын хөтөлбөрт оролцож буй хүүхдүүдэд Музей хэрхэн үзэх, боловсролын хөтөлбөрт оролцох аюулгүй байдал, Музейд ирэх очих замдаа хэрхэн зорчих талаар мэдээллийг хүргэн ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар нийт **9083** хүүхдэд мэдээлэл хүргэн үйлчиллээ.

3. Музейн нүүр хуудсаар дамжуулан хүүхэд хүмүүжил, хүүхдийн эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх талаар цахим мэдээ мэдээллийг 3 удаа олон нийтэд толилуулж **382** үзэгчдэд хүрсэн байна



Хоёр: Хүүхэд хөгжлийн хувийг бий болгоно

Тус газар нь 2023 оны 11 дүгээр сарын байдлаар Музейн орлого **8,788,3450** төгрөг төвлөрсөн байна.

1. 6 дугаар сарын 1-нд Эх үрсийн баярыг тохиолдуулан Музейн Эцэг Эхийн Зөвлөлөөс 8 албан хаагчдын 20 хүүхдийг баярлуулан **360,000** төгрөгийн баярын бэлэг гардуулав.



2. 2023-2024 оны хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан Музейн албан хаагчид өөрсдийн хүүхдүүдийн ангид дархлаажуулалт, витаминжуулалтын аяныг зохион байгуулж нийт **293 200** төгрөг зарцууллаа.



4. 5 дугаар сарын 15-нд Олон Улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Музейн Эцэг Эхийн Зөвлөлөөс “Жаргалтай гэр бүл” явган аялалыг зохион байгуулав. Тус аялалд эцэг эхчүүд хүүхдүүддээ зориулан хоол унд бэлтгэж 8 албан хаагчийн 16 хүүхэд аав, ээжийн хамт аяласан. Мөн Музейд хүрэлцэн ирж “Үйчүүр, хорло” үндэсний тоглоом наадгай тоглов.

Шарын гол сумын Соёлын төв:

Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр соёлын салбарын авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Шарын гол сумын Соёлын төв нь дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулж, хэвшил болгон ажиллаж байна. Үүнд:

Нэг: Хөшиг нээгдэх бүрд хүргэх үг:

Соёл, урлагийн үзвэр, үйлчилгээ, соёл, олон нийтийн ажил бүрийн эхэнд Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдэд үүргийг сануулсан уриалга хүргэж хэвшсэн.

Боловсрол олгох чиглэлээр:

1. “Эерэг хандлага, эерэг сэтгэхүй” сургалтыг “Эртэч-Дархан” клубын эрч хүчтэй эерэг залуу багш нарын EQ түвшин тогтоох буюу EQ таны амьдралд хэрхэн нөлөөлөх түүнийг хэрхэн нэмэгдүүлэх тухай сургалтад 2 дугаар сургуулийн Од багштай 12в ангийн 22 сурагчдыг урьж оролцууллаа.

2. Нэгдүгээрт хүүхэд уриан дор “Хүүхдэд ээлтэй аяны хүрээнд 2 дугаар сургуулийн 6в ангийн хүүхдүүдийг хамруулж уншигчийн карт нээлгэж, ном олгох үйл ажиллагааг зохион байгуулсан. /26 хүүхэд хамрагдаж цахимаар 2190 хүнд хүрсэн/

3. Байгууллагын ажилтан албан хаагчдын 10 хүүхдийг эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд “Хүүхдээ сонсоё” арга хэмжээ зохион байгуулж нийт 273900 төгрөгний зардал гаргасан. /10 хүн хамрагдаж цахимаар 6252 хүнд хүрсэн/

4. СӨБ-ийн 4 байгууллагатай хамтран цэцэрлэг тус бүр номын БОГЦ-ыг эсгийгээр урлаж, номын санд бэлэглэсэн ба бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд үлгэр уншиж танилцуулах харилцан номын тухай ярилцах дүр бүтээх зэрэг үйл ажилгааг хамтран зохион байгуулсан. /24 хүүхэд хамрагдсан/

5. “НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД” уриан дор 2 дугаар сургуулийн сурагчдын авьяас чадварыг нээн илрүүлэх, цаашид хөгжүүлэх, харилцан бие биенээсээ суралцах, урлагийн төрөл зүйл таниулах, сурагчдын урлагийн чадварыг нээн хөгжүүлэх, гоо зүйн төлөвшил олгох зүрилготой зохион байгуулдаг “УРЛАГИЙН НААДАМ”-д хөгжим техникээр дэмжлэг үзүүлэн шүүгчээр хамтран ажилласан. /38 хүн хамрагдаж цахимаар 3206 хүнд хүрсэн/

6. Номтой хүүхэд хөтөлбөр ЕБС-ийн сурагчдад номын сангийн үйл ажиллагааг сурталчилан таниулж, байнгын ном унших боломжийг бүрдүүлсэн./32 хүүхэд хамрагдсан/

Цахим соёлын чиглэлээр:

1. Сумынхаа авьяаслаг хүүхдүүдийн авьяас чадварыг нээх, сурталчлах, дэмжих, цаашид хөгжүүлэх нөлөөллийн ажил болох “Хүүхдийн ертөнц” цуврал контент бэлтгэн хүргэсэн. /8300 хүнд хүрсэн/

2. Соёлын тухай хууль, соёлын өвийн тухай хуульд заасны дагуу Соёлын өвийн хадгалж, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах зорилготойгоор үндэсний баяр наадмын босгон дээр соёлын өв тээгч бяцхан унаач хүүгийн талаарх контент хүргэсэн. /3300 хүнд хүрсэн/

3. Шарын гол сумынхаа нэрийг олон удаа амжилтаараа гайхуулан шагшуулан мандуулж буй авьяаслаг бахархам баг хамт олныг энэ удаагийн контентоор онцолсон. /8900 хүнд хүрсэн/

4. Байгууллагын болон ГХУС цахим хуудсуудаар дамжуулан гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж шийдвэр, зурагт хуудас уриалга зэргийг иргэд олон нийтэд хүргэсэн. /702 хүнд хүрсэн/

Тусламж үйлчилгээний чиглэлээр:

“Өгөх нь авахаасаа илүү” аяныг эхлүүлснээр аянд 2 байгууллага, 8 иргэн нэгдэж өөрт байгаа хэрэглэгдэхгүй зүйлсээ зорилтот бүлгийн 11 өрхийн 20 хүүхэд, 7 насанд хүрсэн иргэнд хандивлалаа.

Хоёр: Хүүхэд хөгжлийн хувийг бийл болгоно

2023 онд нийт **6 143 000** өөрийн орлогоо төвлөрүүлсэн. Үүнээс хүүхэд хамгааллын чиглэлээр хүүхдийг сурч боловсроход, соён гэгээрүүлэхэд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулав. Үүнд:

- “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын арга хэмжээнд хүүхдийн оролцоог дэмжиж 120 000 төгрөг
- “Бяцхан мисс” арга хэмжээнд 1 223 600 төгрөг
- Хүүхдийн оролцооны "INDEPOS MAKERS" АСУУДАЛ+ГАРЦ+ШИИДЭЛ хэлэлцүүлэгт 299 000
- “Уран жиргээ” арга хэмжээнд 1 223 600 төгрөг
- “Эмэгтэй танд хаяглах захидал” аянд 705 000 төгрөг тус тус зарцуулж нийт 3 571 200 төгрөг зарцууллаа.

Орхон сумын соёлын төв:

Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр соёлын салбарын авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Шарын гол сумын Соёлын төв нь дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулж, хэвшил болгон ажиллаж байна. Үүнд:

Нэг: Хөшиг нээгдэх бүрд хүргэх үг: "Хүүхдэд ээлтэй орон нутаг", "Бид дээрэлхэлтийг тэвчихгүй"

Тус соёлын төв нь 2023 онд хүүхэд багачуудад нийт 13 үзвэр үйлчилгээг 250 хүүхдэд үзүүллээ. Үзвэр үйлчилгээний өмнө хөшиг нээгдэх бүрд хүргэх үгийг хэлж хэвшсэн.

Орон нутаг судлах танхимд 2023 онд 128 үзүүллэгийг 134 хүүхэд хамрагдаж, номын сангийн ном олгох 283 үйл ажиллагаанд 233 хүүхэд хамрагдаж ном унших, гэрийн даалгавраа хийх, соёл, олон нийтийн 74 үйл ажиллагааг тус тус зохион байгууллаа.

Аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр:

2023 оны 10 дугаар сарын 14-өөс 20-ныг хүртэлх хугацаанд хүүхдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор Улаанбаатараас-Сүхбаатар, Сүхбаатараас-Улаанбаатар чиглэлийн суудлын воган ирж явах хугацаанд тогтмол эргүүл хийж зөрчил гаргаагүй.

Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх чиглэлээр:

Үе тэнгийн хүүхдүүд бие биедээ туслах, дэмжих мөн ахмад настнаа хүндлэх, чөлөөт цагаа зөв боловсон үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор анги хамт олноороо сайн үйлсийн ажлыг тогтмол хийсэн хүүхдүүдэд спорт заал болон караокегоор үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн бичгээр шагналаа.

Тус соёлын төвд 2023 оны хагас жилийн байдлаар сагсан бөмбөг, шатрын дугуйланд ЕБС-ийн 60 гаруй сурагч идэвхтэй хичээллэж, хүүхэд багачуудад Монголчуудын үндэсний өв соёл болон уламжлалт тоглоом наадгай, үндэстэн ястны үндэсний хувцас танилцуулах зэрэг соён гэгээрүүлэх ажлыг тус тус зохион байгуулсан. Цаашлаад тус соёлын төв нь номын сангийн буландаа хүүхэд залуучуудад зориулан шинэ үлгэрийн болон танин мэдэхүйн номоор булан тохижуулж, ая тухтай цэвэрхэн орчноор хүүхэд багачууд болон иргэдэд үйлчилсээр байна.

Орхон сумын Соёлын төв нь ЕБС-тай хамтран сар шинийн баярыг угтаж “Дээлтэй Монгол” хөтөлбөр зохион байгуулж Орон нутаг судлах танхимдаа урьж уламжлалт ахуй соёл, тоглоом наадгайгаар наадаж нийт 120 хүүхэд багачуудад үйлчиллээ.

Хоёр: Хүүхэд хөгжлийн хувийг бий болгоно

2023 оны 10 дугаар сарын байдлаар тус соёлын төв **1 677 000** төгрөг төвлөрүүлсэн бөгөөд хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр олон талт үйл ажиллгааг зохион байгуулсан. Үүнд:

1. Сумын дотуур байрны бага насны хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ЕБС-ийн 35 сурагчдын цүнх нь дээр нь цацруулагч оёж өглөө. /65 000/
2. “Хүүхдээ сонсьё” санал хүсэлтийн хайрцагыг байгууллага дээр байрлуулж соёлын төвөөр үйлчлүүлсэн хүүхдүүдээс санал авч байна. Улиралд нэг удаа хайрцгийг нээж дүн шинжилгээ хийнэ. /45 000/
3. 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн эх үрсийн баяраар ЕБС-ийн 19 сурагч сумын иргэд, хүүхэд багачуудад “Залгамж” урлагийн тоглолтыг толилуулж тоглолтод оролцсон сурагчдад тус соёлын төвөөс гарын бэлэг гардуулав. /285 000/

Хүүхэд хамгааллын чиглэлээр хүүхдийн хөгжлийг дэмжиж нийт **395 000** төгрөг зарцуулав.

Хонгор сумын Соёлын төв:

Хүүхдийн эрхийг хангах чиглэлээр соёлын салбарын авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Хонгор сумын Соёлын төв нь дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулж, хэвшил болгон ажиллаж байна. Үүнд:

Нэг: Хөшиг нээгдэх бүрд хүргэх үг: “Гараас-гарт”, “Бяцхан гар”

Тус соёлын төв нь 2023 онд нийт 614 үзвэр үйлчилгээг сумын 6768 иргэд, олон нийтэд хүргэж ажиллалаа. **Үүнд:** 131 хүүхэд багачууд хамрагдсан. Үзвэр үйлчилгээний өмнө хөшиг нээгдэх бүрд хүргэх үгийг хэлж хэвшсэн.

Орон нутаг судлах танхимд 2023 онд 21 хүүхэд хамрагдаж номын санд ном унших, гэрийн даалгавраа хийх, соёлын боловсрол олгох үйл ажиллагаанд 106 хүүхдийг хамруулсан байна.

2023 оны 09 дүгээр сард хүүхэд хамгаалал, боловсролыг дэмжих дэд хөтөлбөр боловсруулах хэлэлцүүлгийг зохион байгуулж эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгч нарт тэдгээрийн хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагын талаар сануулж “Гараас-гарт” аяныг уриалж сумын 60 гаруй иргэн оролцсон.

2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 11, 14, 16 дугаар сургуулийн 80 гаруй хүүхэд урлагийн тоглолтод оролцож 350 гаруй иргэд, хүүхэд хамрагдсан. Мөн 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн Үндэсний их баяр наадмын урлагийн тоглолтод 35 хүүхэд оролцож 900 гаруй иргэд, олон нийт үзэж сонирхсон.

2023 оны 06 дугаар сарын 27-оос 28-ны өдрүүдэд “Бяцхан гар” уриалгыг дэвшүүлж хүүхэд эцэг эхээсээ төөрөх, алга болох гэх мэт болзошгүй эрсдэлээс урьдчилсан сэргийлсэн 6 нөлөөллийн ажлыг хийж цахимд байршуулан 4200 хүнд хүргэсэн.

2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Шинэ үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойг тохиолдуулан төр, төсвийн байгууллагын 20 албан хаагчийн дунд хүүхдийн эрхийн тухай хуулийн хоёрдугаар бүлэг хүүхдийн эрх, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг 5, 7, 10 дугаар зүйлийн зүйл заалтуудаас оролцуулан “Аха” тэмцээнийг зохион байгуулсан.

Хоёр: Хүүхэд хөгжлийн хувийг бий болгоно

2023 оны 11 дүгээр сарын байдлаар тус соёлын төв **3 071 000** төгрөг төвлөрүүлсэн бөгөөд хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр сумын СӨББ болон ЕБС-уудын хүүхэд багачуудыг витаминжуулалт болон дархлаажуулалтад **1 сая** гаруй төгрөг зарцуулсан. Үүнд:

Дархан-Уул аймаг

Соёл, урлагийн газар

2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Энхийн Тун эмийн сантай хамтран XVI цэцэрлэгийн Ахлах бүлгийн 25 хүүхэд, XIV сургуулийн 1 дүгээр ангийн 31 хүүхэд, 2 дугаар ангийн 23 хүүхэд, ЗДТГазар, Эмт наран ОНӨААТҮГ, Хонгор хот тохижилт ОНӨААТҮГ-ын албан хаагчид болох 100 хүнд халуун аарц чацаргана, витамин С-гээр даржжуулалтын ажлыг хийж зохион байгуулсан юм.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН.

СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Б.ДОЛГОРМАА